



**БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар № 02

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1, 76.1, 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.1 дэхь заалт, Бөөний худалдаа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн

“Бөөний худалдаа” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03-р сарын 04-ний өдрийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Бөөний худалдаа ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2024 оны 04-р сарын 22-ны өдрийн 15.00 цагт Баянгол дүүрэг, 20-р хороо, Сонсголон, Бөөний худалдаа ХК-ийн оффисын байранд хуралдуулсугай.
2. Бөөний худалдаа ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
  - 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
  - 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн талаар ТУЗ-аас гаргасан тогтоол
  - 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
  - 2024 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.5-д заасны дагуу бүртгэлийн өдрийг 2024 оны 03-р сарын 25-ны өдрөөр тасалбар болгохоор тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ҮЦТХТ ХХК-ийн 2024 оны 03 сарын 25-ны өдөр (бүртгэх өдөр)-өөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалгаар үндэслэн тогтоосугай.
5. Компанийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар /Хавсралт1/-ыг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.



**БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны ... сарын ... өдөр

Дугаар №

Улаанбаатар хот

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хурлыг зохих журмын дагуу явуулахыг Хурал зохион байгуулах комиссын дарга С.Наранцэцэгт даалгасугай.
7. 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Балжинням овогтой Дөлбадрахыг томилсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараахь бүрэллэхүүнтэй томилсугай.  
Тооллогын комиссын дарга Б.Баянжаргал  
Тооллогын комиссын гишүүн Ц.Нарантуяа
9. Компанийн тухай хуулийн 67.3, 67.4-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлж санал хураалтын дүнг үнэн, зөв гаргаж хариуцлагатай ажиллахыг Тооллогын комисст үүрэг болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт2-т заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04-р сарын 19-ний өдрийн 18 цагаар тасалбар болгосугай.
12. Хурал хуралдуулах шийдвэрийг гаргаснаас хойш ажлын 3 хоногийн дотор Бөөний худалдаа ХК-ийн ТУЗ-ын тогтоол, хавсралт материалууд, СЗХ-ноос баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл” маягтын хамт Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д тус тус хүргүүлэхийг ТУЗ-ын дарга Б.Дөлбадрахад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ДӨЛБАДРАХ